

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлгэрмөрөн Шишхэд голын сав газрын захиргааны 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/031/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyam@audit.gov.mn

Гурван Хөх Морьт Аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Н.Отгончимэг
Утас: 99051815 Цахим хаяг: gurvankhukhmoritllc@gmail.com
Аудитор: Ш.Саранчимэг
Утас: 99834361 Цахим хаяг: gurvankhukhmoritllc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/282
танай _____-ны № _____-т

ДЭЛГЭРМӨРӨН ШИШХЭД ГОЛЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЭНХГЭРЭЛ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлгэрмөрөн Шишхэд голын сав газрын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 10,068.3 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 12,797.0 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжөөр нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан бэлтгээгүй, цахим системд бүрэн нийтлээгүй, ахмадын сан байгуулаагүй, үндэслэлгүй ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгосон, шилэн дансанд байршуулах мэдээллийг орхигдуулсан, хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг зөрчил илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

Дэлгэрмөрөн шишхэд голын сав газрын захиргааны дарга нь БОУАӨЯ-ны сайдаар 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө батлуулан 97.3 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6725021088

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,170,920.00	15,383,120.00
33	АВЛАГА	138,500.00	-
333	Татаас, санхүүжилтийн авлага	138,500.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	2,032,420.00	15,383,120.00
351	Түүхий эд материал	205,920.00	205,920.00
3511	Тусгай зориулалттай материал	205,920.00	205,920.00
354	Хангамжийн материал	1,826,500.00	15,177,200.00
3541	Бичиг хэргийн материал	200,000.00	754,800.00
3542	Аж ахуйн материал	1,626,500.00	2,751,800.00
3544	Түлш, шатах тослох материал	-	11,339,300.00
3545	Барилгын засварын материал	-	331,300.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	310,408,618.32	324,207,872.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	310,408,618.32	324,207,872.60
392	Биет хөрөнгө	310,408,618.32	324,207,872.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	318,813,246.50	318,813,246.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,358,500.08)	(24,921,270.86)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	15,751,348.00	36,547,148.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,401,593.95)	(6,828,506.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,552,809.84	9,552,809.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,948,691.99)	(8,955,554.49)
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	312,579,538.32	339,590,992.60
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	345,961.75	89.97
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	345,961.75	89.97
413	Өглөг	345,961.75	89.97
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	345,961.75	89.97
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	312,233,576.57	339,590,902.63
51	Засгийн газрын хувь оролцоо	312,233,576.57	339,590,902.63
512	Хуримтлагдсан үр дүн	312,233,576.57	339,590,902.63
5121	Өмнөх үеийн үр дүн	312,233,576.57	312,233,576.57
5122	Тайлант үеийн үр дүн	-	27,357,326.06
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	-
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	312,579,538.32	339,590,992.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	528,405,896.50	798,364,760.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	298,404,596.50	10,068,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	298,404,596.50	10,068,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	269,647,496.50	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	269,647,496.50	-
120009	Бусад орлого	28,757,100.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	10,068,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	230,001,300.00	788,296,460.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	230,001,300.00	699,895,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	230,001,300.00	699,895,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	88,400,660.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	74,393,660.00

Дэлгэрмөрөн Шишхэд голын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	--	13,772,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	235,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	259,362,036.19	771,007,433.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	259,362,036.19	771,007,433.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	242,229,530.19	707,876,041.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,040,261.76	265,299,040.93
210101	Үндсэн цалин	112,952,813.87	153,396,699.43
210102	Нэмэгдэл	31,803,673.86	56,756,096.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,551,708.68	35,892,000.00
210104	Урамшуулал	10,732,065.35	19,254,244.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,711,900.00	32,500,409.91
210201	Тэтгэврийн даатгал	14,763,800.00	23,005,176.67
210202	Тэтгэмжийн даатгал	1,771,077.76	2,418,843.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,380,539.28	1,179,686.65
210204	Ажилгүйдлийн даатгал	345,134.80	1,177,686.65
210205	Эрүүл мэндийн даатгал	3,451,348.16	4,719,016.61
2104	Хангамж, бараа материалын зардал	25,796,894.00	36,131,037.00
210401	Бичиг хэрэг	984,900.00	13,675,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,118,960.00	20,370,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	980,034.00	932,577.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,713,000.00	1,152,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	129,900.00	7,145,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	129,900.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	146,800.00
210604	Урсгал засвар	-	6,998,400.00
2107	Томилолт, зочны зардал	4,014,600.00	19,901,600.00
210702	Дотоод албан томилолт	4,014,600.00	19,901,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,288,400.00	335,009,007.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,991,900.00	333,219,761.27
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	279,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,000.00	356,746.30
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	396,000.00	73,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,247,574.43	11,889,745.72
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,577,000.00	4,893,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,670,574.43	6,996,545.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,132,506.00	63,131,392.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,087,500.00	18,910,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,087,500.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	13,310,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	45,006.00	44,221,392.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,006.00	44,221,392.81
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	269,043,860.31	27,357,326.06
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	269,043,860.31	27,357,326.06

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	258,758,400.00	788,434,960.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,757,100.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	28,757,100.00	-
120009	Бусад орлого	28,757,100.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	230,001,300.00	788,434,960.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	230,001,300.00	699,895,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	230,001,300.00	699,895,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	88,539,160.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	74,532,160.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	13,772,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	235,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	258,758,400.00	777,707,460.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	258,758,400.00	777,707,460.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	241,487,394.00	714,576,067.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	173,694,300.00	265,642,912.71
210101	Үндсэн цалин	112,606,852.11	153,740,315.95
210102	Нэмэгдэл	31,803,673.86	56,756,096.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,551,708.68	35,892,000.00
210104	Урамшуулал	10,732,065.35	19,254,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,711,900.00	32,502,409.91
210201	Тэтгэврийн даатгал	14,763,800.00	23,005,176.67
210202	Тэтгэмжийн даатгал	1,771,077.76	2,418,843.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,380,539.28	1,179,686.65
210204	Ажилгүйдлийн даатгал	345,134.80	1,179,686.65
210205	Эрүүл мэндийн даатгал	3,451,348.16	4,719,016.61
2104	Хангамж, бараа материалын зардал	25,821,894.00	46,781,137.00
210401	Бичиг хэрэг	1,057,300.00	12,630,500.00
210402	Тээвэр, шатахуун	6,118,960.00	30,074,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	965,734.00	1,827,977.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,679,900.00	2,248,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,139,300.00	7,705,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,992,500.00	560,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	146,800.00	146,800.00
210604	Урсгал засвар	-	6,998,400.00
2107	Томилолт, зочны зардал	4,014,600.00	19,901,600.00
210702	Дотоод албан томилолт	4,014,600.00	19,901,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,288,400.00	335,572,807.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,991,900.00	333,783,561.27
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	279,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,000.00	356,746.30
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	73,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	396,000.00	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,817,000.00	6,470,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,817,000.00	6,470,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,271,006.00	63,131,392.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,087,500.00	18,910,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,087,500.00	-

Дэлгэрмөрөн Шишхэд голын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	13,310,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	183,506.00	44,221,392.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	183,506.00	44,221,392.81
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	10,727,500.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	10,727,500.00
	Дотоод эх үүсвэрээр	-	10,727,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	10,727,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(10,727,500.00)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			43,189,716.25	43,189,716.25
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			43,189,716.25	43,189,716.25
7	Тайлант үеийн үр дүн			269,043,860.31	269,043,860.31
10	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл			312,233,576.57	312,233,576.57
17	Тайлант үеийн үр дүн			27,357,326.06	27,357,326.06
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			339,590,902.63	339,590,902.63

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	699,895,800.00	655,916,991.19	43,978,808.81	93.7
2	НИЙТ ЗАРЛАГА	699,895,800.00	655,916,991.19	43,978,808.81	93.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	699,895,800.00	655,916,991.19	43,978,808.81	93.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	669,823,000.00	642,606,991.19	27,216,008.81	95.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,902,700.00	265,642,912.71	23,259,787.29	91.9
210101	Үндсэн цалин	161,695,000.00	153,740,315.95	7,954,684.05	95.1
210102	Нэмэгдэл	68,353,200.00	56,756,096.76	11,597,103.24	83.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,600,000.00	35,892,000.00	3,708,000.00	90.6
210104	Урамшуулал	19,254,500.00	19,254,500.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,112,700.00	32,502,409.91	3,610,290.09	90.0
210201	Тэтгэврийн даатгал	24,556,700.00	23,005,176.67	1,551,523.33	93.7
210202	Тэтгэмжийн даатгал	2,889,000.00	2,418,843.33	470,156.67	83.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,444,500.00	1,179,686.65	264,813.35	81.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,444,500.00	1,179,686.65	264,813.35	81.7
210205	Эрүүл мэндийн даатгал	5,778,000.00	4,719,016.61	1,058,983.39	81.7
2104	Хангамж, бараа материалын зардал	26,635,200.00	26,635,177.00	23.00	100.0
210401	Бичиг хэрэг	1,668,000.00	1,668,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	22,529,600.00	22,529,600.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,828,000.00	1,827,977.00	23.00	100.0

Дэлгэрмөрөн Шишхэд голын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	609,600.00	609,600.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,146,800.00	14,145,200.00	1,600.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,000,000.00	7,000,000.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	146,800.00	146,800.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	7,000,000.00	6,998,400.00	1,600.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	10,774,600.00	10,774,600.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	10,774,600.00	10,774,600.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	284,433,500.00	284,089,191.57	344,308.43	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	282,300,000.00	282,299,945.27	54.73	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	279,500.00	279,500.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	603,000.00	356,746.30	246,253.70	59.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	135,000.00	73,000.00	62,000.00	54.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	396,000.00	360,000.00	36,000.00	90.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,817,500.00	8,817,500.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,817,500.00	8,817,500.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,072,800.00	13,310,000.00	16,762,800.00	44.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,072,800.00	13,310,000.00	16,762,800.00	44.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,762,800.00	0.00	16,762,800.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,310,000.00	13,310,000.00	0.00	100.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	699,895,800.00	655,916,991.19	43,978,808.81	93.7
122005	Төсвөөс санхүүжих	699,895,800.00	655,916,991.19	43,978,808.81	93.7
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	88,539,160.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	88,539,160.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,696,576.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,835,960.00
210401	Бичиг хэрэг	11,652,500.00
210402	Тээвэр, шатахуун	7,544,960.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,638,500.00
2107	Томилолт, зочны зардал	9,127,000.00
210702	Дотоод албан томилолт	9,127,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,483,616.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51,483,616.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,250,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,600,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	242,584.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	242,584.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	88,539,160.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	88,539,160.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	74,393,660.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,772,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	373,500.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11,382.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 5,257.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож 6,125.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 19,350.0 мянган төгрөгийн 1 алдааг аудитын хугацаанд залруулсан. Үүнд:

- Төвлөрсөн хогийн цэгийг түрж булахад гарсан хоол, хүнс, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн материалыг бүртгэлд тусгаагүй байсныг бүртгэл тайланд тусгуулж аудитын хугацаанд залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, орон тоог давхардуулсан шийдвэр гаргаж, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл цалин болон ажил олгогчийн шимтгэлийн зардалд нийт 5,257.3 мянган төгрөгийг олгож төсвийн үр ашгийг бууруулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2."чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох", БОАЖС-ын 2028 оны А/168 дугаар тушаалын 6 дугаар хавсралт болон НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3."холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтуудтай нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага тогтоогоогүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллаатай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан бэлтгээгүй, цахим системд нийтлээгүй, тендер шалгаруулалтын аргыг буруу ашигласан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ" гэж заасныг тус тус зөрчсөн, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах" журмын 2.1-т "Худалдан авах ажиллагааны зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 44 дүгээр зүйл болон энэ журамд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна" гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны тухай хууль, журмыг мөрдөж худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллах.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээнээс 476,935.8 мянган төгрөгийн 20 мэдээлэл, орлогын 116,292.6 мянган төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй, 39 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" дахь заалт болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн ил тод байдлыг хангаж, Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн, үнэн зөв мэдээлж ажиллах.

3. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулан бүртгэхгүйгээр шууд зардалд нийт 6,125.0 мянган төгрөгийг бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1."Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 8 дугаар зүйлийн 8.2."Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана" 20 дугаар зүйлийн 20.2.3."холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт болон "Үнэлгээ ба хуваарилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулан НББ-ийн тухай хууль тогтоомжийг бүрэн мөрдөж ажиллах.

4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус газар нь ахмадын сан байгуулж ажиллаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ахмад настны тухай Ахмад настны тухай хуульд заасны дагуу Ахмадын сан байгуулж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Fas.audit.mn сайтад мэдээлж баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НББ-ийн тооцооллын алдаа	1	19,350.0	1	19,350.0			1	19,350.0		
Дүн	1	19,350.0	1	19,350.0			1	19,350.0		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндэслэлгүй нэмэгдэл олгосон	1	5,257.3	1	5,257.3				
НББ тайлагналтай холбоотой	1	6,125.0					1	6,125.0
Дүн	2	11,382.3	1	5,257.3			1	6,125.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авах ажиллагааны хууль журмыг баримтлаагүй	1				1	
Шилэн дансны тухай хуулийг бүрэн мөрдөж ажиллаагүй	1				1	
Ахмадын сан байгуулаагүй	1				1	
Дүн	3				3	